

МАХИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙНТОГТООЛ

2023 оны 03 сарын 13 өдөр

№2

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.1 дэх заалт, 62.1.9, 62.1.13 дахь заалт, 64.1,64.2,64.4,65 дугаар зүйл, 67.1, 71.1, 71.3,76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018.12.14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын зар мэдээг хүргэх” журмын 2 болон 3 дугаар зүйлийн заалт болон 2021.01.27 ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны 45 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан 4 дүгээр бүлэгт заасан заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Махимпэкс” ХК ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цагт компанийн өөрийн байрнаас цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр оруулсугай. Үүнд:
 1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
 2. Компанийн 2023 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг батлах
 4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг хэлэлцэн батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 4 дугаар сарын 04-ний өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг “Санхүүгийн Зохицуулах Хороо”, “Хөрөнгийн Бирж”-д мэдэгдэх өдрийг 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2023 оны 03 дугаар сарын 18 ны өдөр болон 4 дүгээр сарын 02 ны өдрүүдэд байхаар тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай зарыг 2023 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршуулах, 3 дугаар сарын 18-ны өдөр болон 4 дүгээр сарын 02-ны өдрүүдэд өдөр дутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Дараах бичиг баримтуудыг компани дээр 2023 оны 3 дугаар сарын 28-ны дотор бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд
 - 6.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай болон Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар
 - 6.2 Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас гарах шийдвэрийн төсөл
 - 6.3 Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан, 2023 оны бизнес төлөвлөгөө
 - 6.4 Хурлын санал хураах хуудас
 - 6.5 Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн намтар, 2023 оны төсөв
 - 6.6 Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд зориулсан танилцуулга
7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №01-ээр баталсугай.
8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 13:00 цагаар тогтоосугай
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг энэхүү шийдвэрийн Хавсралт №02-оор баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг энэхүү шийдвэрийн Хавсралт №03-аар баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Л.Янжин, нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга И.Өлзийбаяр, тэргүүлэгчдээр хувьцаа эзэмшигч Д.Самдан, Ж.Сүхболд нарыг сонгосугай.
12. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

Комиссын дарга:	И.Галтхүү	/Ахлах Нягтлан бодогч/
Гишүүд:	Ч. Мөнх-Очир	/Нягтлан бодогч/
	Д.Нямсүрэн	/Нягтлан бодогч/
	Л.Хулан	/Нягтлан бодогч/
	Д.Бурмаа	/Нягтлан бодогч/
	Б.Хонгорзул	/Нягтлан бодогч/

13. Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлын зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

Комиссын дарга:	Н.Одгэрэл	/Үйлдвэрийн дарга /
Нарийн бичгийн дарга:	И.Өлзийбаяр	/ТУЗ-ийн н/б/ дарга/
Гишүүд:	Н.Маралсүрэн	/Ерөнхий инженер/
	Б.Идэрээ	/Маркетингийн албаны дарга/
	М.Жаргалмаа	/Хуулийн зөвлөх/
	Х.Баянмөнх	/Хүний нөөцийн менежер/
	П.Энх-Амгалан	/Дэд захирал/
	А.Билгүүн	/ЗХНАлбаны дарга/

2. Компанийн Хувьцаа Эзэмшигчдэд танилцуулах хурлын материал, танилцуулгыг тараах, хурлын бэлтгэл ажлыг сайтар зохион байгуулж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын дарга /Н.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ЦЭНГҮҮН